



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 16 өдөр

Дугаар Б/29.

Чингис хот

Зарим албан хаагчид олгож буй
нэмэгдлийг зогсоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 04/1587 дугаар “Ажлын хэсгийн тайланд тусгагдсан зөрчлийг арилгах тухай” албан бичигт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны орон нутаг дахь төлөөлөгчөөр ажиллаж байгаа Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Нямдаваа, Бүртгэлийн мэргэжилтэн Б.Цэцэгмаа, жендэрийн мэргэжилтний ажил үүргийг хавсран гүйцэтгэж байгаа Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Г.Лхагвахатан, Эрүүл мэнд, нийгмийн даатгал, жендэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн Ж.Цэнджав нарын ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зогсоосугай.

2. Тус нэмэгдлүүдийг 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хасаж тооцохыг нягтлан бодогч /Г.Ариунхүү/-д зөвшөөрсүгэй.

3. Шийдвэрийг холбогдох албан тушаалтнуудад танилцуулах, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан ахлах мэргэжилтэн /Ж.Саруултөгс/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР